



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2006 оны 7 сарын 18 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

Захирамжид нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 2-ын 4 дүгээр заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 156 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2006 оны 257 дугаар захирамжаар байгуулагдсан "Ашиглалтын өмнөх захиргаа"-г Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болгосугай.

Хоёр. "Ашиглалтын өмнөх захиргаа" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дарга Х.Эрдэнэбилэгтэй гэрээ байгуулж ажиллахыг Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т даалгасугай.

Гурав. "Ашиглалтын өмнөх захиргаа" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2006 оны 314 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



“АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГАА” ОНӨУУГ-ЫН /ЗАХИАЛАГЧИЙН ТОВЧОО/ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг “Ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨУУГазар нь /цаашид “газар” гэнэ/ хотын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, бусад төрлийн эх үүсвэр бүхий нийслэл хотын захиалгатай орон сууц, инженерийн байгууламж, далан суваг, гэрэлтүүлэг, нийгмийн салбарын ахуйн болон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга, объектыг шинээр барих, шинэчлэн өргөтгөх, засварлах ажилд батлагдсан хөрөнгийг зориулалтынх нь дагуу зарцуулах, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах захиалагчийн үүрэг бүхий мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, тогтоомж, барилгын норм, норматив, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр техник хяналтын зардлаас санхүүжин нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын эрхтэйгээр бие даан үйл ажиллагаа явуулна.

1.4. Газар нь Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч дарга, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.5. Газрын дарга нь хотын төсвийн батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах бөгөөд батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсдыг томилох, чөлөөлөх асуудлыг газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ. Ажлын шаардлагад зохицуулан тодорхой хугацаагаар гэрээгээр мэргэжлийн хүн авч ажиллуулж болно.

1.6. Хотын хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн зураг төсвийг захиалж хийлгэхэд байгууллагуудын баталсан зураг төсөв боловсруулах, батлах, зөвшөөрөлцөх заврыг мөрдлөг болгоно.

1.7. Газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Газар нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн нийгэм, эдийн засгийн зорилгод тулгуурлан хагас жил, жилийн төлөвлөгөөтэй ажиллаж, жилд 2 удаа Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнах бөгөөд газрын даргыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлнө.

2.2. Газрын дарга нь орлогч дарга, ерөнхий инженер, хэлтсийн даргатай байж болно.

2.3. Газрын дарга нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг баталж, цалингийн хэмжээг тогтоож мөрдүүлэх бөгөөд ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.4. Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий захиргааны зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын Дотоод журмаар зохицуулна.

2.5. Газрын даргын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулан ажиллана.

2.6. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг холбогдох хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай барагдуулах, өргөдөл гомдлын барагдуулалтыг тухай бүр тайлагнаж байна.

Гурав. Газрын гүйцэтгэх үүрэг

3.1. Газар нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

3.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, тухайн оны нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр үнэн бодитой гаргана.

3.3. Нийслэл хотын хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4. Нийслэлийн захиалгаар шинээр барих, их засвар хийх, нийгмийн салбарын болон бүх барилга байгууламж, далан суваг, гэрэлтүүлгийн болон бусад ажилд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцон жил, хэтийн төлөвлөгөө, зорилтод тусгуулан тухайн ажлыг захиалан гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавина.

3.5. Барилга, хөрөнгө оруулалтын норм, норматив, дүрэм, журам, заавар, бусад хууль эрхийн актыг мөрдөж хэрэгжүүлнэ.

3.6. Нийслэлийн захиалгаар шинээр барих, өргөтгөх, засварлах барилга, инженерийн байгууламжийн зургийн даалгаврыг батлуулж, түүний дагуу зураг төсвийн зохиогчийг сонгон шалгаруулж, зураг төсвийг гэрээгээр захиалан хийлгэнэ. Бэлэн болсон зураг төсвийг улсын экспертизээр хянуулж гэрээг дүгнэнэ.

3.7. Хотын захиалгаар баригдах, засварлах бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлэг, барилгын ажлын захиалагчаар ажиллахын дээр гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн монголын талын хариуцах барилга угсралтын бүх ажлыг хэрэгжүүлж гардан зохион байгуулна.

3.8. Гүйцэтгэх барилга угсралт, шугам сүлжээ, их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, санхүүжүүлэх мөн хотын захиалгатай барилгын засварын ажлыг гүйцэтгэх найдвартай гүйцэтгэгч байгууллагуудыг ажлын шаардлагаар сонгон шууд гэрээ байгуулж болно.

3.9. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн мэдээг сар бүр гаргаж Статистик, мэдээлэл судалгааны газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст өгч байна.

3.10. Барилга угсралт, их засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу хийлгэж, ил. далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг гаргуулан барилга угсралтын ажлын материалыг Улсын төв архивт, их засварын ажлын материалыг байгууллагын архивт хүлээлгэж өгнө.

3.11. Газар нь орлогоороо зарлагаа нөхөж ажиллах бөгөөд хөрөнгө, санхүүгийн чадавхи нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөө гарган аж ахуйн тооцоон дээр ажиллан, захиалгаар ажиллаж буй барилга угсралт их засварын ажлын техник хяналтын зардлаас үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх зарчмаар ажиллана.

3.12. Нийслэлийн тулгамдсан асуудалтай холбогдсон төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсээр хянуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад өргөн мэдүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.13. Хүний хүчин зүйлийг барилга угсралтын ажилд оновчтой зохион байгуулж, захиалагчийн хяналтыг явуулна.

3.14. Газрын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана

3.15. Хөрөнгө оруулалтыг дэмжих, боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх зэрэг асуудлаар бусад орны туршлагыг судлах, хамтран ажиллах гадаад харилцааны чиг бодлогыг тогтоож хэрэгжүүлнэ.

3.16. Ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ

Дөрөв. Газрын эрх

4.1. Барилга байгууламж, их засварын ажлыг гүйцэтгэх технологийн дараалал, батлагдсан зураг төслийг зөрчиж чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажлыг буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэж, улсыг хохиролгүй болгоно.

4.2. Хэрэв буруутай этгээд гаргасан зөрчил дутагдлаа арилгаагүй тохиолдолд тухайн байгууллагын барилга угсралт, их засварын ажлыг уг зөрчлийг арилгатай зогсооно.

4.3. Барилга угсралт, их засварын ажлын төсөвт нөхөн сэргээх ажлын зардлыг тусгуулж, түүний үндсэн дээр урьдын байдалд оруулна.

4.4. Гүйцэтгэгч байгууллага тухайн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулснаас гарсан хохирлыг арилгуулахын тулд банк, санхүү, хуулийн байгууллагаар хянуулж шалгуулна.

4.5. Барилга угсралт их засварын ажлын техникийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага, зураг төслийн зохиогчийн оролцоотойгоор явуулж, зөрчил доголдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд зохих хууль дүрмийн дагуу холбогдох байгууллагын хүмүүст хариуцлага хүлээлгэх асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

4.6. Стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаагүй материал ашиглахыг хатуу хориглож, шаардлагатай бол эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулна.

4.7. Барилга угсралт, их засварын ажил дууссаны дараа барилга ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгч, комиссоос тогтоосон гүйцэтгэгч байгууллагаас хариуцах чанарын баталгаат хугацааг мөрдүүлнэ.

4.8. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, барилгын ажлын норм, норматив, үнэлгээний дагуу хянаж, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажилд тохирсон санхүүжилтийн эрх нээх санхүүжилт хийх, дутуу гүйцэтгэсэн ажлаас санхүүжилтийг хасна.

4.9. Барилга угсралт, их засварын ажлын норм, норматив, үнэлгээ, зураг төсөлд оруулах санал боловсруулж Барилга, хот байгуулалтын яам болон бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.10. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэхийн зэрэгцээ нийслэлийн төр захиргааны байгууллагуудтай үйл ажиллагааныхаа чиглэлүүд дээр хамтран ажиллана.

4.11. Газрын хүний хүчин зүйл болон тэдний ажиллах нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ авна.

4.12. Бусад эрх

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1. Газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын татвар төлнө.

5.2. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хотлон, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.4. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.5. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд хөндлөнгийн шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.6. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.7. Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баримтлана.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах.

6.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч өөрийн эрх мэдлийн хүрээнд газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Газрын дарга, ажилтнууд нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн Дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2. Хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Бусад

8.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oOo-----